

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <i>Шатахуун худалдан авах</i>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: <i>ЗГАБ/20240102004</i>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багц № 1: Хот дотор үйлчилгээ үзүүлэх автомашинд шатахуун нийлүүлэх</i> <i>Багц № 2: Хөдөө орон нутагт үйлчилгээ үзүүлэх автомашинд шатахуун нийлүүлэх</i>
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <i>Үгүй</i>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Өөрийн хөрөнгө</i>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <i>НӨАТ-тай дүн 1,784,364,600 /Нэг тэрбум долоон зуун наян дөрвөн сая гурван зуун жаран дөрвөн мянга зургаан зуу/ төгрөг.</i> <i>Багц №1: 892,402,600 / Найман зуун ерин хоёр сая дөрвөн зуун хоёр мянга зургаан зуу/</i> <i>Багц №2: 891,962,000 /Найман зуун ерин нэгэн сая есөн зуун жаран хоёр мянга/</i>
Б. АГУУЛГА	
ТШЗ 8.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын худалдан авалт хариуцсан ажилтан Д.Буянжаргал Хаяг: Монгол Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 6-р хороо Их тойруу, Баянбүрдийн зүүн тал “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ өөрийн байр Утасны дугаар: <i>323441</i> Цахим шуудангийн хаяг: <i>info@zgab.gov.mn</i>
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <i>Үгүй</i>